



**МОНГОЛ УЛС
ХЭНТИЙ АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН
ЗАХИРАМЖ**

2017 оны 02 сарын 23 өдөр

Дугаар А/87

Хэрлэн сум

Ажлын хэсэг байгуулах тухай

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж түүний удирдлагын тухай хуулийн 29 дүгээр зүйлийн 29.2, 29.1.6-ын "а", Хөдөлмөрийн тухай хуулийн 11 дүгээр зүйлийн 11.5, 20 дугаар зүйлийн 20.4.4 дэх заалтыг тус, тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1. Хэнтий аймгийн 2017-2018 оны "Хөдөлмөр, нийгмийн зөвшлийн гурван талт хэлэлцээр"-ийг бэлтгэж танилцуулах ажлын хэсгийг дараах бүрэлдэхүүнтэйгээр байгуулсугай.

Дарга:	Ж.Ганбаатар	-Аймгийн Засаг даргын Тамгын газрын дарга
Гишүүд:	Ж.Гантулга	-Төрийн захиргааны удирдлагын хэлтсийн дарга
	Г.Лхагвахатан	-Нийгмийн бодлогын хэлтсийн дарга
	Л.Бат-Октябрь	-Хууль, эрх зүйн хэлтсийн дарга
	Э.Мөнх-Эрдэнэ	-Хөрөнгө оруулалт, хөгжлийн бодлого төлөвлөлтийн хэлтсийн дарга
	С.Эрдэнэжаргал	-Хөдөлмөр, халамжийн үйлчилгээний газрын дарга
	Т.Эрдэнэбаатар	-Ажил олгогч эздийн холбооны тэргүүн
	Д.Оюун	-Үйлдвэрчний эвлэлийн холбооны дарга
Нарийн бичгийн дарга:	Х.Болоргэрэл	-Нийгмийн бодлогын хэлтсийн мэргэжилтэн

2. Хэлэлцээрт тусгах асуудлыг нарийвчлан боловсруулж 3 талын оролцоотойгоор гурван талт хэлэлцээр батлуулах ажлыг зохион байгуулахыг Ажлын хэсэг /Ж.Ганбаатар/-т даалгасугай.

ЗАСАГ ДАРГА



Н.ГАНБЯМБА